

ГАРЧИГ

Х.2

Хүний эрхийг хүндэтгэхэд юуг анхаарах вэ?

Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэхийн ач холбогдол

Х.3

Удирдамжийн зорилтууд

Хүний эрхийн хамрах хүрээ

Хүний эрхийг хүндэтгэх арга замууд

Х.4

Хүний эрхийг хүндэтгэхэд хэрэгжүүлэх алхмууд

АЛХАМ 1 Хүний эрхийн бодлого боловсруулах, нийтлэн мэдээлэх

АЛХАМ 2 Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх

АЛХАМ 3 Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх

Х.5

Бизнесийн байгууллагуудын кейс судалгаа

Х.6

Хүний эрхийн магадлан шинжилгээний үе шатууд

Х.8

Хүний эрхийн магадлан шинжилгээний тухай эх сурвалжууд

Хүний Эрхийн Магадлан Шинжилгээ

Хариуцлагатай ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх Хүний эрхийг Хүндэтгэх тухай Удирдамж

Товчилсон хувилбар

Албан бус орчуулга:

Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Бизнес ба хүний эрх” глобал төслийн дэмжлэгтэйгээр орчуулж, хэвлэв.

Хүний эрхийн магадлан шинжилгээ гэж юу вэ?

Хүний эрхийн магадлан шинжилгээг хэн хийх үүрэгтэй вэ?
Манай компани ч мөн адил хийх ёстой юу?

Хүний эрхийг хүндэтгэхэд миний зүгээс юуг анхаарах ёстой вэ?

Манай компани ажилтнуудынхаа хүний эрхийг хүндэтгэхэд анхаарч ажилладаг нь хангалттай биш гэж үү?



Хүний эрхийг хүндэтгэхэд юуг анхаарах вэ?

- 2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Бизнес ба хүний эрхийн Удирдах зарчмуудыг санал нэгтэй баталснаар бизнесийн байгууллагууд хүний эрхийг хүндэтгэн ажиллахыг шаардах олон улсын хүчин чармайлтыг улам эрчимжүүлэв.
- Япон Улсын Засгийн газар мөн НҮБ-ын Удирдах зарчмуудад үндэслэн 2020 онд Бизнес ба хүний эрхийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг (2020–2025 он) боловсруулжээ.
- 2021 оны 11 сард нийтлэгдсэн Япон компаниудын ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх хүний эрхийг хүндэтгэх арга хэмжээний талаарх санал асуулгын үр дүнгээс харахад Япон Улсын Засгийн газраас энэ чиглэлээр удирдамж гаргуулах хүсэлт компаниудын дунд их байжээ.
- Одоогоор ихэвчлэн Европын улс орнууд дотоодын хууль тогтоомжиндоо бизнесийн байгууллагуудыг хүний эрхийг хүндэтгэж ажиллах үүргийг тусгаж байна.
- Япон Улсын Засгийн газраас уг Удирдамжийг (1) НҮБ-ын Удирдах Зарчмууд, ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан компанийн удирдамж, ОУХБ-ын Үндэстэн дамнасан компанийн тухай тунхаглал болон бусад олон улсын стандартуудад тулгуурлан (2) тодорхой, ойлгоход хялбар байдлаар жишээн дээр үндэслэн боловсруулав.




Бизнесийн үйл ажиллагаанд Хүний эрхийг хүндэтгэхийн ач холбогдол

- Хүний эрхийг хүндэтгэн ажилласнаар бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх боломжтой.
- Дээрх арга хэмжээний үр дүнд бизнесийн байгууллагууд тогтвортой эдийн засаг, нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулж, нийгмээс тэдэнд хүлээлгэх итгэлийг олох, компанийн үнэ цэнээ хадгалж, нэмэгдүүлэх боломжтой болно.

Удирдамжийн зорилтот бүлгүүд

Зорилтот бизнес эрхлэгчид


Япон Улсад үйл ажиллагаа эрхэлдэг бизнесийн бүх байгууллагууд



Хүний эрхийг хүндэтгэж ажиллах зорилтот бүлгийн хамрах хүрээ

Бизнесийн байгууллагууд, групп компаниуд, бизнесийн шууд болон шууд бус түншүүд, Япон болон гадаад улс дахь бизнесийн бусад түншүүд

“Бизнесийн түншүүд” гэдэгт ханган нийлүүлэлтийн сүлжээний эхэн үе болон сүүлд оролцогч түншүүд багтана.



Хүний эрхийн хамрах хүрээ

Удирдамжид заасан “Хүний эрх” гэх нэр томъёо нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хэлнэ. Үүнд, Олон улсын хүний эрхийн биллд тусгагдсан эрх болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн үндсэн зарчим ба эрхийн тухай” тунхаглалд заасан үндсэн эрхийн талаарх зарчмууд орно. Тодорхойлбол, хүний эрхийн нэр томъёонд албадан болон хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрөөс ангид байх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрх, хөдөлмөр эрхлэлт, ажлын байран дээр ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрх, арьсны өнгө, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, нийгмийн гарал үүсэл, хүйс эсхүл бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх хамаарна.

Хүний эрхийг хүндэтгэх арга замууд

1 Удирдлагын түвшний үүрэг амлалт чухал ач холбогдолтой.

Бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа, тухайлан ажилд авах, томилох, худалдан авалт хийх, үйлдвэрлэх, борлуулахдаа хүний эрхийг хүндэтгэн ажиллах ёстой. Эдгээр үйл ажиллагаанд бизнесийн бүх талууд оролцох шаардлагатай.

2 Аливаа бизнесийн байгууллагад хүний эрхийн зөрчил гарах эрсдэл байдаг.

Бизнесийн байгууллагууд хүний эрх зөрчигдөх эрсдлийг хэрхэн тодорхойлох, урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч үзэн, болзошгүй сөрөг нөлөөлөлд авч хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ тухай олон нийтэд мэдээлэх нь нэн чухал байна.

3 Оролцогч талуудтай хийх зөвлөлдөх уулзалт чухал ач холбогдолтой.

Оролцогч талууд (бизнесийн түншүүд, бизнесийн байгууллагын ажилтнууд, групп компаниуд, үйлдвэрчний эвлэл, ажилчдын төлөөлөл, хэрэглэгчид, иргэний нийгмийн байгууллага болон бусад аж ахуйн нэгж, аж үйлдвэрийн байгууллагууд, хүний эрхийг хамгаалагчид, ойролцоох оршин суугчид, уугуул иргэд, хөрөнгө оруулагчид болон хувьцаа эзэмшигчид, засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон бусад байгууллагууд)-тай хүний эрхийг хүндэтгэх бүхий л арга хэмжээний хүрээнд зөвлөлдөх уулзалт хийж байх нь чухал. Жишээлбэл, бизнесийн байгууллагууд зөвлөлдөх уулзалтын үеэр хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн бодит байдал, шалтгааныг ойлгохыг хичээх хэрэгтэй.

4 Эн тэргүүнд шийдвэрлэх асуудлаа тодорхойлсны дараа арга хэмжээ авах.

Хэрэв бүхий л арга хэмжээг нэг дор хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзвэл бизнесийн байгууллагууд хамгийн ноцтой хүний эрхийн сөрөг нөлөөллийг тэргүүн ээлжинд шийдвэрлэхэд анхаарах ёстой.

5 Бизнесийн байгууллага бүрийн хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой.

Хүний эрхийг хүндэтгэн ажиллахдаа бизнесийн байгууллагууд хоорондоо хамтран ажиллах ёстой. Бизнесийн байгууллага нь түншүүддээ хүний эрхийг хүндэтгэх арга хэмжээ авахыг шаардсан хэрнээ гэрээгээрээ дамжуулан дангаараа хэт их дарамт учруулж байгаа тохиолдолд туслан гүйцэтгэгчийн хувьд Туслан гүйцэтгэгчийн төлбөрийг хойшлуулахгүй байх тухай хууль мөн Хувийн монополичлолыг хориглох, Шударга худалдааг хангах тухай хуулийг тус тус зөрчсөн байж болзошгүй юм.



Хүний эрхийг хүндэтгэхэд хэрэгжүүлэх алхмууд

АЛХАМ 1

Хүний эрхийн бодлого боловсруулах, нийтлэн мэдээлэх

Хүний эрхийн бодлого боловсруулах

● Бизнесийн байгууллагууд дараах 5 шаардлагыг хангасан хүний эрхийн бодлогоор дамжуулан байгууллагын дотоод болон гадаад орчинд хүний эрхийг хүндэтгэх тухай үүрэг амлалтаа илэрхийлэх нь зүйтэй.

Хүний эрхийн бодлогод тавигдах 5 шаардлага:

- 1 Бизнесийн байгууллагын хамгийн дээд удирдах түвшнээр батлагдсан байх
- 2 Бодлогыг боловсруулах үйл явцад бизнесийн байгууллагын дотоод ба гадаад мэргэжилтнүүд оролцсон байх
- 3 Бизнесийн байгууллагын ажилтнууд болон бизнесийн түнш, мөн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй шууд хамаарал бүхий бусад талууд нь тухайн байгууллагаас хүний эрхийг хүндэтгэх тал дээр ямар хүлээлттэй байгааг тусгасан байх
- 4 Олон нийтэд нээлттэй байх буюу бизнесийн байгууллагын ажилтнууд, бизнесийн түншүүд болон бусад холбогдох бүхий л талуудад мэдээлсэн байх
- 5 Бизнесийн байгууллагын үйл ажиллагааны бодлого, дүрэм журамд тусгагдсан байх

АЛХАМ 2

Хүний эрхийн магадлан шинжилгээ

→ Тодорхой үйл явцыг 6, 7-р хуудсанд танилцуулав.

● Хүний эрхийн магадлан шинжилгээ гэдэг нь бизнесийн байгууллага, түүний групп компани, ханган нийлүүлэгчийн сүлжээн дэх бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн сөрөг нөлөөллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хариу арга хэмжээний үр дүнг хянах, сөрөг нөлөөллийг хэрхэн шийдвэрлэснээ тайлагнан олон нийтэд мэдээлэх цогц арга хэмжээг хэлнэ.

● Хүний эрхийн магадлан шинжилгээ нь оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулан хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулахад чиглэсэн тасралтгүй явагдах үйл явц юм.

АЛХАМ 3

Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизм

● Бизнесийн байгууллага хүний эрхийн сөрөг нөлөөлөл учруулсан нь тодорхой болсон тохиолдолд тухайн бизнесийн байгууллага уг хүний эрхийн сөрөг нөлөөллийг арилгах эсхүл арилгахад хамтарч ажиллах ёстой.

● Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизмын тодорхой жишээнээс дурдвал уучлалт гуйх, хохирлыг барагдуулах, нөхөн сэргээх, санхүүгийн болон санхүүгийн бус нөхөн олговор олгох, дахин зөрчил гаргахгүй гэсэн баталгаа гаргах эсхүл мэдэгдэл хийх, ханган нийлүүлэгчдэд дахин зөрчил гаргахгүй байх талаар хүсэлт тавих зэрэг орно.

● Бизнесийн байгууллагууд өөрсдийн гомдол барагдуулах механизмыг бий болгох эсхүл салбарын болон бусад байгууллагын гомдол барагдуулах механизмд оролцох замаар зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх боломжийг олгодог байх ёстой.

● Төрөөс зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх механизмд шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөн Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ЭМХНХЯ)-ны хөдөлмөрийн маргааныг бие даан шийдвэрлэх тогтолцоо, ГХЯ, ЭМХНХЯ болон Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам (ЭЗХАУЯ)-наас бүрдсэн Японы Үндэсний маргаан шийдвэрлэх төв, Хууль зүйн яамны (ХЗЯ) Хууль зүйн товчооноос үзүүлэх хүний эрхийн зөвлөгөө, хянан шалгалт, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх журам болон Техникийн дадлагажигч бэлтгэх байгууллагын дэргэдэх Эх хэлний зөвлөл зэрэг багтана.


Кейс судалгаа

Зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх механизм

Бизнесийн байгууллагын гадаад дахь ханган нийлүүлэгч нь үйлдвэрчний эвлэл байгуулахыг зөвшөөрдөггүй. Арбитрын байгууллагаас үйлдвэрчний эвлэл байгуулахыг зөвшөөрөх ёстой гэсэн шийдвэр гарсан боловч тус ханган нийлүүлэгч шийдвэрийг биелүүлээгүй. Улмаар ханган нийлүүлэгчийн ажилтнууд тухайн бизнесийн байгууллагатай зөвлөлдөн тус ханган нийлүүлэгчийг арбитрын шийдвэрийг биелүүлэхийг уг бизнесийн байгууллага уриалав.

Гомдол барагдуулах механизм

Бизнесийн байгууллага нь дотоод ба гадаадын ханган нийлүүлэгчийн ажилтнууд ашиглах боломжтой мэдээлэл хүлээж авах утастай байв. Гадаад дахь ханган нийлүүлэгчийн ажилтнуудаас ажлын байран дахь хүний эрхийн зөрчлийн талаар олон тооны гомдол ирүүлсний дагуу бизнесийн байгууллага нь тус ханган нийлүүлэгчийн удирдлагад асуудлыг дэвшүүлж, гомдол барагдуулах хороо байгуулахыг хүссэн байна.





Бизнесийн байгууллагын кейс судалгаа

“А” химийн үйлдвэрлэлийн авсан арга хэмжээний жишээ

АЛХАМ 1 Хүний эрхийн бодлого боловсруулах, нийтлэх

Үүнд компанийн хүний эрхийн боловсрол, сургалт, хүний эрхийн магадлан шинжилгээ, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизм, компаний ил тод байдал, оролцогч талуудтай хийх зөвлөлдөх уулзалт зэрэг хүний эрхийн талаар авч хэрэгжүүлэх үндсэн арга замыг тусгасан байна.

АЛХАМ 2 Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх

1 Хүний эрхийн сөрөг нөлөөллийг илрүүлэх, үнэлэх

Бизнесийн байгууллага, групп компани: Бизнесийн байгууллагын зүгээс хяналт шалгалт хийх, бизнесийн байгууллага, групп компанийн хүний эрхэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөлд хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх, улмаар хүний эрхийн сөрөг нөлөөллийг үнэлэх.

Бизнесийн түншүүд: Бизнесийн түншүүдийн хүний эрхийг хүндэтгэхийн тулд авч буй арга хэмжээний талаар санал асуулга явуулах, газар дээр нь шалгалт хийх замаар судлах.

2 Хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах

Бизнесийн түншүүдийн хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сайжруулах тал дээр зааварчилгаа өгөх зорилготой цахим семинар зохион байгуулах

Худалдан авах ажиллагааны удирдамжийг бизнесийн түнш компаниудад түгээх

3 Хариу арга хэмжээ, түүний үр дүнтэй байгаа эсэхийг хянах

Бизнесийн байгууллагаас хийх үнэлгээ: худалдан авах ажиллагааны удирдамж, санал асуулгыг дахин хянах
Гуравдагч талаас хийх үнэлгээ: олон улсын төрийн бус байгууллагууд болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт хийж, тэдний зөвлөгөө, үнэлгээнд үндэслэн сайжруулалт хийх

4 Нийтлэн мэдээлэх

Мэдээллийг вэбсайтад байршуулах: Хүний эрхийг хүндэтгэн ажиллахаар хийж буй ажил, хүчин чармайлтын үр дүн, гадны мэргэжилтнүүдийн зөвлөгөөг компанийн вэбсайтад нийтлэх.

АЛХАМ 3 Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх

Дотоод мэдээллийн систем (бизнесийн байгууллагын ажилтнуудад зориулсан): Баримт мэдээллийг олж тогтоох ажиллагаа явуулах, анхаарах ёстой асуудлыг хөндөх, засаж залруулга хийхэд шаардлагатай мэдээллийг өгөх, мэдээлэгчийг ямар нэгэн эрсдэлд оруулахгүйн тулд нөхцөл байдалд хяналт тавих

Гомдол барагдуулах механизм: Бизнесийн түнш байгууллагын ажилтнуудад зориулсан мэдээлэх системийг нэвтрүүлэх талаар хэлэлцэж байна.

“Б” хүнс үйлдвэрлэгчийн авсан арга хэмжээний жишээ

“Б” компани нь бизнесийн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй хүний эрхийн сөрөг нөлөөллийг илрүүлж үнэлэн, улмаар байгаль орчинд ээлтэй түүхий эд худалдан авчээ.

Ингэхдээ хамгийн түрүүнд тодорхой нэг ханган нийлүүлэлтийн сүлжээний ажилтнуудад сөргөөр нөлөөлөх нэн даруй анхаарах ёстой хүний эрхийн асуудлыг нь шийдвэрлэжээ.



Бодлого боловсруулж, байгаль орчинд ээлтэй түүхий эд худалдан авах арга хэмжээ авсан нь

Худалдан авалтын бодлого боловсруулах

Тус компанийн бүтээгдэхүүнийг хүнсний бүтээгдэхүүнээс эхлээд химийн бодис хүртэл өргөн хүрээний хэрэглээнд ашигладаг бөгөөд хөдөө аж ахуйн хөгжүүлэлтийн улмаас ой мод устаж үгүй болох, албадан хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр зэрэг хүний эрхийн сөрөг нөлөөлөл бий болж буй асуудлууд гарч байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхээр тус компани худалдан авалтын бодлого боловсруулсан ба үүнд тус бизнесийн группын ханган нийлүүлэлтийн сүлжээнд үйлдвэрлэсэн бүхий л бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад ой модыг сүйтгэхгүй байх, хүлрийг устгахгүй байх, аливаа мөлжлөгөөс ангид байх тухай үүрэг амлалтыг тусгажээ.

Ханган нийлүүлэгчдийг дэмжих (чадавхыг бэхжүүлэх)

Тус компани нь орон нутгийн групп компаниудаараа дамжуулан ханган нийлүүлэлтийн сүлжээнийхээ ажиллах орчныг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Тус хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн тариалан, фермийн менежерүүдтэй биечлэн уулзаж, дагаж мөрдөх журмын талаар мэдээлэл, баримт бичгээр хангахын сацуу ханган нийлүүлэгчдийнхээ үйл ажиллагаан дахь хүний эрхийн сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч ажиллах талаар холбогдох ажилтан, албан хаагчдад сургалт явуулжээ.



Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх 4 үе шат

1 Хүний эрхийн сөрөг нөлөөлөл, зөрчлийг илрүүлэх, үнэлэх

- Бизнесийн байгууллагууд нь өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанаас шууд үүдэлтэй, эсвэл групп компани, бизнесийн түншүүд зэрэг ханган нийлүүлэлтийн сүлжээний үйл ажиллагаанаас хамааралтайгаар үүсч болох хүний эрхийн аливаа сөрөг нөлөөлөл, зөрчлийг илрүүлж, ноцтой байдлын түвшинг үнэлнэ.
- Хүний эрхийн бүх асуудлыг нэн даруй шийдвэрлэхэд хүндрэлтэй бол хүний эрхийн зөрчлийн ноцтой байдлын түвшинд үндэслэн нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай байгаа хүний эрхийн асуудлыг шийдвэрлэнэ.

Хүний эрхийн сөрөг нөлөөлөл, зөрчлийг илрүүлэх аргууд


- Олон улсын байгууллагаас гаргасан мэдээллийг ашиглан судалгаа хийх (лавлах материалыг удирдамжид оруулав)
- Бизнесийн түншүүдэд санал асуулга илгээх
- Газар дээр нь очиж танилцах
- Холбогдох оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт хийх

Дээрхийг зөвхөн жишээ өгөх зорилгоор оруулав. Бизнесийн байгууллагууд тодорхой нөхцөл байдалдаа үндэслэж, зохих хянан шалгах аргыг ашиглах нь зүйтэй.

Зөрчилдөөн болон бусад нөхцөл байдалд нэрвэгдсэн бүс нутгийн эмзэг бүлэг, бизнесүүдийг анхаарч үзвэл зохистой.


Тогтмол явагдах нөлөөллийн үнэлгээ

Хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг (жишээ нь, аюултай ажлын орчинд ажиллах) үнэлэхийн тулд бизнесийн байгууллагын үйлдвэрийн ажилтнуудаас тогтмол санал асуулга, ярилцлага авах зэрэг аргаар үнэлнэ. Ингэхдээ ажил олгогч нь ажилтнуудад саналаа нууц, чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгосон байх хэрэгтэй.



Холбогдох мэдээллийг цуглуулах

Хүний эрхийн зөрчлийн мэдээллийн санд үндэслэн бизнесийн байгууллагын зүгээс хүний эрхийн сөрөг нөлөөлөл (жишээ нь албадан хөдөлмөр болон хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр г.м) учирч болзошгүй салбар, бүс нутгийг илрүүлж, ханган нийлүүлэгчдийнхээ нөхцөл байдлыг шалгана.



Хүний эрхийн зөрчлийн мэдээллийн сан

Хүний эрхийн сөрөг нөлөөлөлд учирч болзошгүй салбар, бүс нутгийг илрүүлэх

Оролцогч талуудын

4 Нийтлэн мэдээлэх

- Бизнесийн байгууллагууд хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлж байгаа талаар мэдээлдэг байх ёстой. Хүний эрхийн сөрөг нөлөөлөл учирсан гэх мэдээлэл ялангуяа оролцогч талуудаас бизнесийн байгууллагад хандсан тохиолдолд бизнесийн байгууллага нь авсан арга хэмжээгээ мэдээлэх хэрэгтэй.
- Хүний эрхийн бодитой зөрчил илэрсэн тохиолдолд ч авсан хариу арга хэмжээнийхээ талаар мэдээлэх нь тухайн бизнесийн байгууллагын үнэ цэнийг бууруулахгүй юм. Эсрэгээрээ энэ нь тухайн бизнесийн байгууллагын үйл ажиллагаагаа сайжруулах хүсэл эрмэлзэл, ил тод байдлыг харуулах тул тухайн бизнесийн байгууллагын үнэ цэнэ нэмэгдэж, хувьцаа эзэмшигчдээс сайшаал хүртэх ч боломжтой. Ингэхдээ бизнесийн байгууллагууд өнгөрсөн хойно нь биш урьтач нийтлэн мэдээлдэг байх нь чухал юм.

Тайлагнах, мэдээлэх арга замын жишээ

Бизнесийн байгууллагын хэмжээнд хүний эрхийн бодлогыг бий болгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ; материаллаг эрсдэлийг илрүүлсэн салбар; хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил, эрсдэлийг илрүүлэх, эрэмбэлэх; тэргүүлэх чиглэлтэй уялдсан шалгуур үзүүлэлт; эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга хэмжээний талаарх мэдээлэл; үр дүнг хянасан тухай мэдээлэл.

Нийтлэн мэдээлэх арга замууд

Бизнесийн байгууллагууд нь мэдээлэл хүлээн авч буй хүмүүст хүртээмжтэй байдлаар мэдээлэл өгөх хэрэгтэй. Жишээлбэл, олон нийтэд мэдээлэхдээ байгууллагынхаа вэбсайтад байршуулах гэх мэт. Нөгөөтэйгүүр, хүний эрхийн сөрөг нөлөөлөл учирсан эсхүл учирч болзошгүй оролцогч талуудад мэдээлэл өгч байгаа тохиолдолд цахимаар яриа хэлэлцээ хийх эсхүл биечлэн уулзалт зохион байгуулах нь зүйтэй.

② Хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах

Бизнесийн байгууллагууд хүний эрхийн сөрөг нөлөөлөл бий болгосон тохиолдолд

Бизнесийн байгууллагууд хүний эрхийн сөрөг нөлөөлөл “бий болгож” эсхүл бий болоход “хувь нэмэр оруулж” буй аливаа үйл ажиллагаагаа түр зогсоох эсвэл таслан зогсооход анхаарч, ирээдүйд “бий болгох” эсхүл бий болоход “хувь нэмэр оруулах”-аас урьдчилан сэргийлэх шаардлагатай. Үйл ажиллагаа, гэрээ, хууль эрх зүйн асуудлаас шалтгаалж түр зогсоох эсвэл нэн даруй дуусгавар болгоход хүндрэлтэй байгаа үйл ажиллагааны хувьд үе шаттайгаар тус үйл ажиллагааг түр эсвэл бүр мөсөн зогсоох арга зам бүхий зураглал гаргана.

Жишээ арга зам

- Хуулиар хориглосон хэдий ч бизнесийн байгууллага техникийн дадлагажигч оюутнуудын паспортыг хураан авч, тэдний хуримтлалыг захиран зарцуулах гэрээ байгуулжээ. Энэ үйл ажиллагааг илрүүлснээр бизнесийн байгууллага нь бусад хэлтэс болон ханган нийлүүлэгчийнхээ хүрээнд ийм асуудал байгаа эсэхийг шалгаж, энэ нь хууль бус үйлдэл болохыг сануулж, нэн даруй зогсоохыг шаардсан байна.

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа нь хүний эрхийн сөрөг нөлөөлөлтэй шууд холбоотой байх үед

Бизнесийн байгууллага хүний эрхийн сөрөг нөлөөллийг “бий болгосон” эсхүл бий болоход “хувь нэмэр оруулсан” байгууллагуудад өөрийн давуу байдлыг ашиглах замаар хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулахад анхаарч ажиллах нь зүйтэй. Хэрэв бизнесийн байгууллага нь ямар ч давуу байдалгүй бол ийнхүү давуу байдлыг бий болгох, бэхжүүлэх буюу дэмжлэг үзүүлнэ.

Жишээ арга зам

Хилийн чанад дахь ханган нийлүүлэгчийг газар дээр нь очиж шалгахад дотоодын хөдөлмөрийн хуулийг зөрчиж, ажилтнуудыг илүү цагаар тогтмол ажиллуулдаг болох нь тогтоогджээ. Бизнесийн байгууллага тус ханган нийлүүлэгчид бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж, хүргэхэд хангалттай хугацаа олгодог болох нь батлагдсан тул бизнесийн байгууллагын зүгээс тус ханган нийлүүлэгчид хүний эрх зөрчсөн талаар нь хэлж, нэн даруй засаж залруулахыг шаардав.



Бизнесийн харилцааг дуусгавар болгох нь хүний эрхийн сөрөг нөлөөллийг улам хүндрүүлж болзошгүй тул хамгийн сүүлчийн арга гэж үзэж, үүнийг зайлшгүй тохиолдолд л хэрэгжүүлнэ.

ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

③ Хариу арга хэмжээний үр дүнтэй эсэхийг хянах

- Бизнесийн байгууллагууд хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад авсан хариу арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх, эсхүл илүү үр дүнтэй арга хэмжээ байгаа эсэхийг шалгах ёстой.
- Үр дүнг хянахын өмнө өргөн хүрээний мэдээлэл цуглуулах шаардлагатай. Жишээлбэл, бизнесийн байгууллага нь байгууллагын дотоод мэдээллээс гадна (гомдол барагдуулах механизмаас олж авсан мэдээлэл г.м) дотоод болон гадаад оролцогч талуудаас мэдээлэл авах боломжтой.

Үр дүнг хянах тодорхой аргууд

Ажилтнууд, ханган нийлүүлэгчидтэй ярилцлага хийх; санал асуулгын хуудас ашиглах; компанийн үйлдвэр, ханган нийлүүлэгчидтэй газар дээр нь очиж танилцах; аудит хийх; болон гуравдагч талаар санал асуулга явуулах

Дотоод үйл ажиллагаанд үр дүнг хянах шалгуур үзүүлэлтүүд нэвтрүүлсэн жишээ

Хүрээлэн буй орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйгаас гадна хүний эрхтэй холбоотой асуудлаар ханган нийлүүлэгчдэд тогтмол хяналт шалгалтыг зохих хэлтсээс явуулж байх. Хариуцсан хэлтэс нь өмнөх үр дүнтэй харьцуулах замаар хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үр дүнтэй шийдвэрлэсэн эсэхийг шалгаж, онцлох асуудлуудыг удирдлагын хурал болон ТУЗ-д танилцуулж, тайлагнана.



Хүний эрхийн магадлан шинжилгээний тухай эх сурвалжууд

Япон Улсын Засгийн газар, төрийн байгууллагуудаас гаргасан товхимол, материалууд



Япон Улсын Засгийн газар

Ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх хүний эрхийг хүндэтгэх тухай удирдамж **PDF**

https://www.meti.go.jp/english/press/2022/pdf/0913_001a.pdf



Гадаад Харилцааны Яам

Бизнес ба хүний эрхийн кейс судалгааны эмхэтгэл **PDF**

<https://www.mofa.go.jp/files/100348374.pdf>

Хэрэв танд QR кодыг уншуулахад асуудал гарсан бол ойролцоох кодыг хуруугаараа дарж, дахин оролдоно уу.



Японы гадаад худалдааг дэмжих байгууллага (ЯГХДБ)

Ханган нийлүүлэлтийн сүлжээ болон Хүний эрхийн тусгай вэб хуудас

https://www.jetro.go.jp/world/scm_hrm/

Олон улсын үндсэн баримт бичгүүд



Нэгдсэн Үндэстний Байгууллага

Бизнес ба Хүний эрхийн Удирдах Зарчмууд **PDF**

https://www.ohchr.org/sites/default/files/Documents/Publications/GuidingPrinciplesBusinessHR_EN.pdf

2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс уг Зарчмуудыг санал нэгтгэйгээр баталсан. Эдгээрт дараах үндсэн гурван тулгуур зарчмыг дэвшүүлсэн. Үүнд, 1. Хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг, 2. Бизнесийн байгууллагын хүний эрхийг хүндэтгэх үүрэг, 3. Зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх механизм орно. Мөн эдгээр Зарчмуудад хүний эрхийн магадлан шинжилгээ хийхэд бизнесийн байгууллагуудад юу шаардлагатай болохыг тодорхой зааж өгсөн.



ЭЗХАХБ

Үндэстэн дамнасан компанийн удирдамж **PDF**

<http://mneguidelines.oecd.org/OECD-Due-Diligence-Guidance-for-Responsible-Business-Conduct.pdf>

Энэхүү удирдамжийг ЭЗХАХБ-аас 1976 онд боловсруулсан ба үндэстэн дамнасан бизнесийн компаниуд хэрхэн бие даан хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг эрхлэн явуулах тухай зөвлөжээ. Уг удирдамжийг 2011 онд шинэчлэн боловсруулж, хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг, түүнчлэн хүний эрхийг хүндэтгэх бизнесийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг тусгасан байна.



ЭЗХАХБ

Хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаан дахь магадлан шинжилгээний удирдамж **PDF**

https://www.mofa.go.jp/mofaj/gaiko/csr/pdfs/oecd_gm.pdf

Энэхүү удирдамжийг ЭЗХАХБ-аас 2018 онд Үндэстэн дамнасан компанийн удирдамжид практик аргуудыг хангаж өгөх зорилгоор боловсруулсан. Мөн хувцас, гутал, ашигт малтмал зэрэг салбарын төрөл бүрийн эрсдэлд үндэслэн нарийвчилсан гарын авлагуудыг хэвлэсэн байна.



ОУХБ

Үндэстэн дамнасан компани, нийгмийн бодлогын зарчмын гурван талт тунхаглал **PDF**

https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/---emp_ent/---multi/documents/publication/wcms_094386.pdf

Үүнийг ОУХБ-ын Үндэстэн дамнасан компанийн тухай тунхаглал гэж бас нэрлэдэг. Энэхүү баримт бичиг нь нийгмийн бодлого, хүртээмжтэй, хариуцлагатай, тогтвортой бизнесийн үйл ажиллагаа эрхлэн явуулахтай холбоотойгоор бизнесийн байгууллагуудад (үндэстэн дамнасан болон дотоодын компаниудад) өгсөн удирдамжийг багтаасан.



経済産業省

Ministry of Economy, Trade and Industry